

## НҮҮДЭЛЧИН УГСААТНУУДЫН ЭРХЗҮЙ

### 1. Удиртгал

Угсаатны зүйч юм уу, эсвэл угсаатны эрх зүйн мэргэжилтэн бус, энгийн нэгэн хуульч хүн нүүдэлчин улс үндэстнүүдийн эрх зүйг судална гэвэл түүний судалгааны ажил нүүдэлчдийн эрх зүйн тогтолцоог задлан шинжлэхэд голлон чиглэх нь зүйн хэрэг. Тиймийн учир миний бие Чингис хаан хийгээд түүнийг залгамжлагчдын үеийн Монголын Эзэнт гүрэн хууль ёсны тухайд ямаршуухан төсөөлөлтэй байсан талаар тодорхой ойлголт өгөхийг зорьсон болно. Чингэхдээ үүн лүгээ холбогдох эх сурвалж хомсдолтойн учир ерөнхийд нь тоймлон үзүүлэхээс өөр аргагүйд хүрэв. Гэхдээ аливаа нүүдэлчин ард түмэнд хууль ёс гэгч ямар үүрэгтэй байж болох вэ, хуулийн үүрэг ролийн талаар Чингис хаан ямар бодолтой байв гэдэг асуултын хариуг олох нь дээрхээс яавч дутуугүй чухал санагдана.

Нэлээд түгээмэл байдаг нэгэн тодорхойлолтоор бол "эрх зүй" хэмээх ухагдахуунд хүмүүний харилцааг зохицуулах, тэгэхдээ хүмүүн хоорондын зөрчил маргаанаас аль болох зайлсхийх, эсвэл түүнийг уг зөрчил маргаанд зориулан гаргасан тусгай дүрэм журмын дагуу шийдвэрлэдэг байх гэсэн утгаар нийтээр дагаж мөрдөх хууль тогтоомжуудыг хамруулан үздэг. Гэвч хууль тогтоомжоор зөвхөн хүмүүсийн бие биетэйгээ харилцах харилцааг зохицуулдаг гэж үзэх нь учир дутагдалтай. Хойно авч үзэх Монголын эрх зүйгээс харахад ч тийм байна. Эрх зүй нь дээрхээс гадна хийсвэр зарчмуудыг хамгаалан бэхжүүлэхэд чиглэгдсэн байдаг ба эдгээр зарчмыг бид нийгэмд эзлэх байр сууриас нь хамааруулан нийгмийн үнэт зүйлс ч юм уу, нийгэмд хэвшсэн ёс заншил хэмээн нэрлэж болох юм. үүнийг дараах жишээн дээр товч авч үзье. Чингис хааны үед мөрдөж байсан хууль цаазаар бол хонь малыг лалын шашинтны ёсоор нядлах хориотой, зөвхөн

Монгол заншлаар зүрх рүү чиглэсэн гол судсыг тасдан амийг нь гаргахыг л зөвшөөрдөг байжээ. Энэхүү зан үйлийн цаад нарийн үндэр нь эх дэлхийг цусаар бузарлах ёсгүйд оршиж байв. Харин түүхэн баримтаар нэгэнт нотлогдсон зүйл болох Чингис хааны үед бусад шашнуудад нэн хүлээцтэй ханддаг байсан нь дээрх зоригтой төдийлөн нийцэхгүй байна.

Өрнөд Европын соёлын хүрээнийхэн бид “эрх зүй” хэмээх ухагдахууныг авч үзэхдээ өөрийн эрхгүй “төр, улс” хэмээх ухагдахуунтай холбох гэдэг. Чингэхдээ улс болж зохион байгуулагдаагүй бүлэг хүмүүст ч гэсэн өөрсдийн хамтын амьдралыг зохицуулах журам дэглэм хэрэгтэй гэдгийг тэр болгон шууд үзвэл дагдгүй билээ. Ийм хүмүүсийн тухайд дараахь хоёр асуудал онцгой хурцаар тавигддаг. Эдгээр нь хууль хүчин төгөлдөр байх тухай, өөрөөр хэлбэл, хууль гаргах эрх мэдэл хэний гарт байх вэ, мөн тэдгээрийг хэрхэн мөрдүүлэх вэ гэдэг асуудлууд юм. Төрийн зохион байгуулалтгүй нийгэмд ч бас хууль ёс нь хүн амын өдөр тутмын хэрэгцээнд нийцэж байх учиртай. Монголын хууль цаазын бичлүүдэд ч энэ нь тодорхой тусгагдсан байдаг бөгөөд тэр тусмаа хуулийн хэм хэмжээг тогтоох механизмууд хэрхэн бүрдэж байсан нь улам сонирхолтой болж байна.

Балар эртний нийгэмд хууль цаазыг тэнгэр бурхнаас гаралтай зүйл гэж үздэг байв. Тэр бүү хэл хүний оюун ухаанд тулгуурласан хосгүй чанараараа Европын хууль ёсонд ноёрхлоо тогтоож, Европоос гаднахь олон тооны эрх зүйн тогтолцоонд хүчтэй нөлөө үзүүлсэн Ромын эрх зүй хүртэл үүсэл хөгжлийнхөө эхэн үед шашин, хууль цааз хоёрын холбооноос ангид байж чадаагүй юм. Ингээд анх шашны хүрээнд үүссэн хууль цааздаа нэмэлт өөрчлөлт оруулах, эсвэл нийт ард түмний хүсэл зоригийг харгалзах замаар шинэ хууль журам бий болгож байв. Гэхдээ хүмүүний өөрийн томъёолсон эдгээр хуулиас гадна тухайн цаг үеийн нийгэм, улс төр, эдийн засгийн харилцаанаас үл хамааран мөрдөгдөж байдаг бичигдээгүй хуулиудын бүхэл бүтэн тогтолцоо байдгийг мартаж болохгүй. Хуулийн энэхүү хоёр туйлт байдал өнөөгийн биднээс ч хол хөндий байдаггүй билээ. Үндсэн хуулийн 20-р зүйлд хууль, эрх зүй хоёрын хэлхээ холбооны тухай дурдсан байдаг. Гэхдээ сайн талын хуулиудыг заавал тэнгэр бурхан, зөв сэтгэл, байгаль

дэлхийтэй холбон үзэх эсэх нь энд төдийлөн ач холбогдолгүй юм.

Одоо Чингис хааны ноёрхож асан XII, XIII зууны үеийн Монгол орон руугаа эргэн оръё. Тухайлсан хууль тогтоогч гэж байгаагүй нэг ард түмэн буюу ард түмнүүдийн холбоонд хууль ёсыг хэн тогтоож байсан бэ? Ийм асуулт XII зууны монгол овог аймгуудын тухайд хамгийн хурцаар тавигддаг. Янз бүрийн үндэстэн ястнаас бүрдсэн тэдгээр овог аймаг өөр хоорондоо ямагт дайсагналцаж, газар нутгаа булаалдан тэмцдэг байжээ. Хабул хааны үед монголчууд 1139 онд Чин Улсын хааны цэргийг бутцохиж, 1147 онд өөрсөддөө ашигтай энхийн гэрээ байгуулсан байна. Гэвч *Монголын Нууц Товчоон*-д өгүүлснээр бол тэд Хабул хааныг нас нөгчсөний дараа дараа татааруудын эсрэг байлдаанд ялалт байгуулж чадсангүй. Ингээд 1160 он гэхэд л Монголын Эзэнт гүрэн мөхөж, энэ нь Монголын ард түмнийг улс төр, нийгэм, эдийн засгийн уналтанд оруулжээ. Монгол овог аймгууд өөр хоорондоо эв нэгдэлгүй, хагарал бутралтай байв.

“Тэдэнд ахлагч, тэргүүлэгч гэж байдаггүй, овог болгон бие биеэсээ салангид, ганцаараа юм уу хоёул нийлж амь зуудаг. Тэгээд ч хоорондоо эв түнжингүй, үргэлжийн дайн дажин хийж, харилцан дайсагнана. Тэд Хятадын хаанд алба барьж, туйлын ядуу зүдүү амьдрах бөлгөө. Монголчууд нохой, тарвага зурамны арьсаар хувцас хийж өмсөх ба тэднийхээ махыг идэж, бас үхсэн амьтны махаар ч хооллоно. Төмрөөр хийсэн давируул бол Их Эмирийн (Хааны) сүлд юм <sup>1</sup> хэмээсэн байдаг.

Хөхөчү бөө энэ үеийг дурсан Чингис хааны хөвүүдэд хандаж хэлэхдээ, та нарыг төрөхийн урьд

Одтой тэнгэр орчиж  
Олон улс байлдаж  
Орондоо унтах завгүй  
Олзлон булаалдаж байв.  
Хөрст дэлхий хөрвөж

1 The History of the World-Conqueror by 'Ala-ad-Din' Ata-Malik Juweini, vol. I, Manchester 1958, 21-р тал.

Хөвчин улс хямралдаж  
 Хөнжилдөө унтах завгүй  
 Хөнөөлдөн тэмцэлдэж байв...  
 Эргэлзэн бодох чөлөөгүй  
 Элбэлдэн зүтгэж байв.  
 Ухран зугтаах газаргүй  
 Урагшлан байлдаж явав.  
 Амар жаргах аргагүй  
 Алалдан тэмцэж байв"<sup>2</sup> гэсэн билээ.

Байнгын дээрэм тонуул, өшөө авах аян дайны уршгаар отог омгуудын нэгдмэл шинж алдагдаж, ялагдсан отог овгууд ялсан талынхаа бүрэлдэхүүнд орох буюу эс бөгөөс хувь хүмүүст албат харьяат болон хуваарилагддаг байв. Ийм эрчүүдэд хууль журам гэж байсангүй, эзэд нь тэднийг хайр найргүй шулан мөлжиж байсан тул тэднээсээ салан тусгаарлахыг эрмэлзэж байжээ. Эдийн засгийн найдваргүй байдал, гачигдал зовлон нь адал явдал эрэлхийлэгч олон залуу эрчүүдийг отог омгоо орхин, өөрсдөд нь амь зуух баталгаа олгож, цэрэг дайны үйл ажиллагаагаар ч юм уу дипломат уран аргаар тэдэнд ихээхэн олз омог олох, эсвэл хурдан өсч дэвжих боломж олгох аль нэг эзний албанд хүчин зүтгэхэд хүргэж байсан аж.

Гачигдал зовлон, ядуу зүдүү амьдрал, ялагдал дийлэгдэл нүүрлэсэн энэ цаг үед хожмын Чингис хаан болох Тэмүжин мэндэлсэн юм. Түүний эцэг Есүхэй баатар сурвалжит язгууртны бүлэгт багтдаг боловч хаан болж байсангүй. Чингис хаан эхийн хэвлийд буй болсон, эхээс мэндэлсэн тухай домгууд хожим түүний талаар үнэлэлт дүгнэлт өгөхөд чухал ач нөлөө үзүүлсэн байдаг. Тэрхүү домог ёсоор бол Чингис хаан нь эр хүний бус, гэрийн тооноор орж ирэх гэрлийн нөлөөгөөр эхийн хэвлийд үүсчээ. Чингис хааны төрсөн он маргаантай байдаг мэт. Ямар ч байсан тэрээр XII зууны 60-аад оны дундуур төрсөн бололтой. Харин 1227 онд нас нөгчжээ. Монголын эрх зүйн хэм хэмжээ, тэдгээрийг хэрхэн хэрэгжүүлж байсан тухай асуудлыг хөндөхийн өмнө би чухам ямар хуулиудыг авч үзсэн талаараа дурдъя.

<sup>2</sup> Монголын Нууц Товчоон, 254-р зүйл.

Үүнд, юуны өмнө Чингис хааны *Их засаг* (эх сурвалжуудад *Yasa* хэмээн нэрлэсэн нь олонтаа) хуулийг нэрлэх байна. Анхны эх нь хадгалагдан үлдээгүй боловч түүний хэсэг бусад тасархайнууд, мөн агуулгаас нь ишлэн авсан зүйлс перс, араб түүхчдийн эх сурвалжуудаас олддог юм. үүнээс гадна 1320 онд гаргасан Юань Улсын хуулийн эмхтгэл, мөн Дорнод Европ болон баруун Сибирийг хамарч байсан Монголын Эзэнт гүрний нэг бүрэлдэхүүн улс болох Алтан Ордны Улсын *Зарлигууд*-ыг дурдах хэрэгтэй. *Их Засаг*-ийг хууль гэж үзэж болох эсэх, тэрчлэн түүний анх үүссэн цаг хугацааны тухай асуудал маргаантай байдаг. Холбогдох ном хэвлэлд *Их Засаг* үүссэн цаг хугацааг 1206-1225 оны хооронд хэмээн заасан байна.<sup>3</sup>

Цаашилбал, эх сурвалжуудад *Цаазын бичиг* хэмээн нэрлэгддэг монгол хууль яг байсан эсэх, мөн түүний үүссэн цаг хугацаа, агуулга зэрэг нь бас л маргаантай байдаг бололтой. Харин Монгол-Ойрадын *Цаазын бичиг* хэмээх дэвтэр үнэхээр байсан ба түүний зохиогдсон он сарын тухай баримт тов тодорхой байдаг юм. Бүрэн тарж бутарсан монгол овог аймгууд гадны шахалт хавчилгын нөлөөгөөр Хойд болон Баруун Монгол, мөн Хөх нуурын монголчуудаас бүрдсэн дечин дөрвөн хошууны холбоо болон нэгджээ. Ийнхүү хууль цаазын олон тооны хэм хэмжээг цааснаа буулгаж, *Цаазын бичиг* хэмээгчийг зохиолгон дээрх холбоонд нэгдсэн хошуудын нутагт мөрдүүлэхээр харилцан тохирсон байна. Энэхүү холбоог задарсны дараа уг хууль Зүүнгарын Улсад 1789 он хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байжээ. Умард Монголд энэ нь *Долоон хошууны цаазын бичиг* болон өөрчлөгджээ. Төгсгөлд нь зөвхөн Умард Монгол болон түүний зарим нутгуудад 1785 он хүртэл мөрдөгдөж байсан хуулийн эмхэтгэл болох *Халх журам*-ыг дурдсу.

## 2. Их Засаг

Одоогоор мэдэгдээд буй хэсэг бусад тасархайнуудаас үзвэл *Их Засаг (Их Яса)* нь эрх зүйн шинжлэх ухааны өнөөгийн хэллэгээр

3 C. Alinge, *Mongolische Gesetze. Darstellung des geschriebenen mongolischen Rechts (Privatrecht, Strafrecht und Prozess)*, = *Leipziger Rechtswissenschaftliche Studien* 87, Leipzig 1934, 28-р тал.

төр, засаг захиргаа, иргэний болон эрүүгийн эрх зүйг хамарсан дүрэм журмуудын эмхэтгэл байжээ. “Yasa” гэдэг үгийг хятад эх сурвалжуудад түшиглэн нормчилсон зохицуулалт, хэв журмын тухай хууль дүрэм гэсэн утгаар орчуулсан байдаг. Үүнийг монголчуудын дунд хатуу тогтсон ёс заншлын эмхэтгэл гэж үзэх явдал цөөнгүй тохиолддог нь илэрхий байна. Гэвч тийм биш биз ээ. Ингэж үзэх нь агуулгын талаасаа ч, уг хуулийн цогцолборыг монголчууд өөрсдөө хэрхэн ойлгож байсан талаасаа ч үнэн байдалд нийцэхгүй. Хуулийн зарим заалтуудаар шинэ тутам гарч буй асуудлуудыг (тухайлбал, газар ухахыг хориглох гэх мэт) зохицуулж байсан нь илт харагддаг. Энэ хууль Эзэнт гүрнийг үндэслэгч, дээд тэнгэрээс заяагдсан гэх Чингис хааны хүсэл зориг байснаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байжээ. үүнийг бага зэрэг тайлбарлах шаардлагатай. *Их Засаг* бол тэр үеийн Монголын шүүх эрх зүй хийгээд хатуу тогтсон ёс заншилд тулгуурласан хамтын хүмүүжлийн хэрэгсэл байсан юм. Хуулийг бичгээр үйлдсэн явдал ёс заншил үүсэн бий болох тогтолцоонд үлэмжхэн нөлөөлсөн явдал боллоо. Учир нь, ёс заншилд тулгуурласан хууль ямагт өргөжин тэлж өөрчлөгдөж байдаг бол түүнийг цааснаа буулгаснаар тэлэх явц нь хязгаарлагддаг. Эдгээрээс гадна уг хуульчлах үйл явцад XIII зууны үеийн Монголд үүсээд байсан эрэлт хэрэгцээ, юуны өмнө эдийн засаг, улс төрийн шинэ нөхцөл байдлыг тусгасан шинэ шинэ санаа оноо, зарчмууд орж ирэн нөлөөлсөн нь илэрхий. Жишээ нь, дээрх хуульд дампуурлыг зохицуулах тухай заалтууд оруулсныг монголчуудын дунд тогтсон ёс заншлын нэг хэсэг гэж үзэж болохгүй биз ээ.

*Их Засаг*-ийг уйгаржин бичгээр үйлдсэн байдаг. Уг бичгийг Чингис хаан өөрийн тушаал зарлигийг илүү сайн дамжуулах зорилгоор нэвтрүүлсэн юм. Өнөөгийн төсөөллөөс ялгаатай нь гэвэл, *Их Засаг* олон нийтэд нээлттэй бус, зөвхөн хаанд өөрт нь зориулагдсан байсан аж. үүнээс үүдээд уг хуульд заасан хэм хэмжээний тухайд огт өөр ойлголт гарч ирнэ. *Их Засаг* хууль нь ард нийтийн харилцааг зохицуулах заавар гэхээсээ илүүтэйгээр улс төрийн удирдлагын үйл ажиллагааны удирдамж шинжтэй байжээ. Гэхдээ тухайн үед улс төрийн удирдлага, шүүх ажиллагаа хоёрыг өнөөгийн агуулгаар ялгаж салгадаггүй байсныг бодолцох хэрэгтэй. Өгэдэй хааны үед *Их Засаг* хуулийг аливаа хэрэг явдлыг

хууль ёсны болгох хэрэгсэл болгон ашиглаж байсан бололтой байдаг юм.

Зохиогчид *Их Засаг* хуулийг агуулгын хувьд дараах байдлаар ангилж болох болов уу гэж үздэг. Үүнд, удиртгал болон хуульчилсан хэсгийн араас биднийхээр бол гадаад харилцааны тухай гэж болохоор заалтууд орсон байна. Энд өнөөгийн бидэнд мэдэгдээд буй нэг журам бий. Самуун этгээдүүдийг Монголын захиргаанд оруулахаар ятгахын тулд тэдэн рүү тусгай элчүүдийг илгээж байхаар уг журамд заажээ. Гэхдээ *Яса*-гийн үзлээр бол *Яса*-д үл хамаарах бүхий л үндэстэн угсаатныг самуун этгээдэд тооцох учиртай аж. Монголын Эзэнт гүрэн өөрийгөө бусад улсын дунд орших нэг улс биш, дэлхий нийтийг хамарсан Эзэнт гүрний эхлэл гэж үздэг байсан юм. Чингис хааны залгамжлагчдаас өрнийн хаад болон Пап ламд илгээсэн захидлууд энэ талаараа *Их Засаг* үзэл санааг агуулсан байдаг билээ. 1237-1242 оны хооронд баруун этгээдэд хийсэн монголчуудын аян дайн өрнө дахины хилд тулан ирж, тэднийг айлган цочирдуулсан ч түүний ард талд байгаа дэлхийн шинэ их гүрний хэмжээ дамжаа нууц хэвээр үлджээ. Тиймийн учир Пап лам Инноцэнз IV францискан урсгалын санваартан Жиованни дель Пиано дель Карпине (Йоханн Платано Карпини ч гэдэг)-д монголчуудыг тайвшруулан, тэднийг Загалмайтны шашинд оруулах даалгавар өгч Их хааных нь ордон руу илгээсэн байдаг. Ламтан 1247 онд эргэн ирэхдээ Мөнх хааныг залгамжлагч Их хаан Гүюг бол хүчирхэг монгол үндэстний, тэр ч байтугай бүх дэлхийн эзэн юм, хэрэв Пап лам даруйхан түүний захиргаанд орохгүй бол хаан түүнийг дайснаа хэмээн зарлах болно гэсэн хариу авчрав. Энэ утгаараа Монголын Эзэнт гүрний байр сууринаас олон улсын эрх зүйн тухай ярих боломжгүй юм. Яагаад гэвэл, энэ тухай ярих угтвар нөхцөл нь урьдаар тусгаар тогтносон, онолын хувьд ижил тэгш эрх бүхий улс үндэстнүүд байх ёстой болно. Монголын Эзэнт гүрний энэ үзлийг Хятадын Эзэнт Улс болон эртний Грекийн үзэлтэй адилтгаж болох юм. Харин фараонууд болон ефитерүүдийн эзэнт улсууд янз бүрийн үзэл суртлыг номлогч улс гүрнүүд зэрэгцэн орших, улс үндэстнүүдийн хооронд гэрээ хэлэлцээр байгуулахын чухлыг ухаардаг байсан билээ. Нөгөө талаар Монголын хууль тогтоомж гадны элч төлөөлөгчдийн халдашгүй дархан байдлыг хүлээн

зөвшөөрдөг байсан агаад орчин үеийн дипломатын эрх зүй ч гэсэн чухамхүү энэ зарчимд тулгуурладаг ажгуу.

Даргаачийн хэсэг нь эзэн хааны статусын асуудлыг хөндсөн бололтой байна. Энд улсын эзэн нь ердөө л "хаан" гэсэн ганц цол хэргэмтэй байх тухай заалт хадгалагдан үлджээ. Мусульман шашинт эзэн хаадын жишгээр өөр олон цол хэргэмтэй байхыг бө журамгүй хэмээн үзэж шууд татгалздаг байсан аж. Бусад улсын хаад ноёдод илгээсэн захидлуудад Чингис хааныг монгол улсаатны Дээдийн дээд эзэн хаан хэмээн нэрлэжээ. Гэвч *Их Засаг* хуулийн энэ талын заалтууд өнөө үед уламжлан ирсэнгүй.

Чингис хаан чухам юуг үндэслэн хууль цаазаа тогтоодог байв аа? Намайг XII-XIII зууны үед үл тохирох үг хэллэг хэрэглэв гэж бүү эмгээрэй. Чухамхүү Чингис хаан хийгээд түүнийг залгамжлагчид нийгээр хүлээн зөвшөөрдөг хууль цаазын үндэс суурийг бий болгохын төлөө их зүйлийг хийсэн юм шүү.

Чингис хаан өөрөө олон удаагийн аян дайны амжилт, улс төрийн билэг авъяасаараа монгол хийгээд түрэг овог аймгуудын дунд асар их нэр хүнд олж, 1206 онд болсон овог аймгуудын ноёд ахлагч нарын Их Хуралдайгаар Их хаанд өргөмжлөгдсөн билээ. Аян дайнуудаараа ялалт байгуулсан болон хаан оронд сууснаа тэрээр өөрөө "Мөнх тэнгэрийн хүч ивээлээр болов" гэдэг байлаа. Тийм ч учраас цэрэг дайны авъяасаараа шалгарсан нэгнийг эсэргүүцэх, эсвэл Тэнгэр бурхны зарлигийг үл дагах аваас тэнгэрийн тааллыг гажуудуулсан хэрэг хэмээн үздэг байв. Тэнгэрийн энэхүү хайр жишгийн тухай нэгэн бөө 1206 оны Хуралдай дээр Чингис хаанд албан ёсоор мэдэгдэж, Тэнгэртүүнд болон түүнийг залгамжлагчдад дэлхий ертөнцийг захирахыг даалгасан тухай өгүүлжээ. Чингис хаанд тэнгэрийн хишиг хүртээхийг бэлгэдсэн бас нэгэн домогт гардгаар бол түүний өвөг дээдэс Дээд тэнгэрээс гаралтай чоно (домгийн амьтан) байсан аж. Тиймийн учир Чингис хааны Зарлигууд ямагт "Мөнх тэнгэрийн хүчин дор ..." хэмээн эхэлдэг болгоо. Мөн Чингис хааныг төрөхөд ч гэсэн нэгэн гайхамшигтай амьдал тохиосон нь, тэрээр баруун гартаа нөж атган төрсөн гэдэг. Үүгээр түүний дэлхийн эзэн болохыг урьдаас зөгнөжээ. Чингис хаан амьд сэрүүн ахуйдаа эзэмшил нутгаа дөрвөн хэсэг (улс)

болгон хувааж, угсаа залгамжлах дөрвөн хүүдээ хуваарилан өгсөн юм. Тэдний шууд залгамжлагчдын дотроос Чингис хааны эрэгтэй талын хэд хэдэн угсаа залгамжлагчдад эрх мэдлийг хуваарилан олгосон боловч нэг толгойлогчийг сонгуулиар гарган ирж хууль ёсоор өргөмжилдөг, тэр хаан нь өөрийн эзэмшил нутгийн хүрээнээс халин гарсан эрхтэй байжээ. Тухайлбал, ямар ямар аян дайн хийх, хэнийг тухайн бүс нутгийн захирагчаар томилох асуудлыг тэрээр шийддэг байв. Гэвч хоёр дахь их хааныг гэхэд л санал нэгтэй сонгож чадаагүй бөгөөд үүнээс болж үнэн чанартаа хэд хэдэн хаад засаг төрийн хэргийг дур мэдэн явуулж байсан юм. Өвөг дээдэс нь тэнгэр бурхнаас гаралтай гэх үзэл хойч үеийнхэнд нь ч дамжин халдварлаж, тэд өөрсдийгөө тэнгэр заяатай хэмээн итгэсээр иржээ. Түүгээр ч үл барам Чингисийн удмын хаад өөрсдийгөө монголчуудын ёс заншлыг хууль ёсоор хадгалан хамгаалагчид, хууль цаазыг сахиулагчид гэж үздэг байсан аж. Энэ талаасаа бол *Их Засаг* гол үүргийг гүйцэтгэж байсан байх юм.

1338 оны Хятадын нэгэн бичээст монголчуудыг улсыг төвхнүүлэгчид, өөрөөр хэлбэл улс орныг захирагч үндэстэн хэмээн нэрлэсэн байдаг ба ингэж өргөмжлөх хоёр учир шалтгаан байсан. Нэг талаар энэ нь дээр өгүүлсэнчлэн Монголын эрх зүйн үйлчлэх хүрээ маш олон янзын үндэстэн ястнуудыг хамарч, Эзэнт Улсын хууль тогтоомж эдгээр үндэстэн ястны хувьд ч хүчин төгөлдөр мөрдөгдөж байсныг харуулахын зэрэгцээ монгол түмэнд онцгой үүрэг ноогдож байсныг ч мөн давхар нотолж байна. Энэхүү онцгой үүрэг гэдэг нь юуны өмнө *Их хаан* болон түүний удирдлагад байх хаадыг сонгох эрх гагцхүү монголчуудад байсанд оршино.

*Их цэргийн зохион байгуулалт*, Монгол Улсын засаг захиргааны эрх зүйтэй холбоотой зарим нэг дүрэм журмын заалтууд өнөө үед уламжлагдан ирсэн байна. Үүнд, цэргийн зохион байгуулалт хийгээд төрийн зохион байгуулалт нь нэг зүйл юм. Чингис хааны зохион байгуулах аугаа их авъяас чадвар үүнд оршино. Монгол Улс дайн дажин хийгээгүй үедээ ч аян дайны үед мөрдөгдөж байсан тэр бүтэц нь хэвээр хадгалагддаг байжээ. Энэ нь бүх нийтийн дайчилгааг нэн даруй явуулах боломж олгож байсан төдийгүй амжилттай сайн дайтаж яваа аливаа армийн хувьд шийдвэрлэх хүчин зүйл болох нөхөрсөг, хамтач үзлийг төлөвшүүлэхэд

(Үүний ач холбогдлыг өнөө хүртэл дутуу үнэлсээр ирсэн байж ч болзошгүй) ихээхэн тус дөхөм үзүүлэв. *Их Засаг*-т мөн энэ талын зохиоц заалтууд ч байсан байж таарна. Тэдгээрийн нэгийг би энд дурдахыг хүснэм. Цэрэг нэг бүр өөрийн харъяа ангид туслах үүрэгтэй байжээ. Нэг морьт цэрэг авч яваа зэвсэг хэрэглэлээ унагаавал ард нь яваа цэрэг түүнийг нь заавал авах ёстой, энэ үүргээ зөрчсөн цэргийг цаазаар авдаг байв. Хамтач ёсны энэхүү үүрэгт бас сул талууд ч байсан. Тухайлбал, нэг цэрэг оргосон тохиолдолд түүний харъяа анги бүхэлдээ шийтгүүлэх явдал ч гарч байлаа.

*Их Засаг* хуулийн их цэрэгт холбогдох заалтууд нэн чухал юм. Эдгээр нь мөн төрийн тухай заалт гэсэн үг билээ. Түүгээр бол 20-иос дээш насны бүх эрчүүд “цэргийн алба хаах үүрэгтэй” байжээ. Их цэрэг нь аравтын системээр зохион байгуулагдсан, өөрөөр хэлбэл хамгийн доод шатны анги 10 хүнтэй, түүнээс дээш 100, 1 000, 10 000 хүнтэй бүлгүүд гэж байв. өөрийн харъяа ангийг солих хориотой, ангиа сольсон хүнийг цаазаар хороох ялтай байжээ. Мөн ийм цэргийг ангидаа авсан даргыг ч гэсэн цаазлах ёстой байсан байна. Их цэргийн дотор хааны бие хамгаалах хишигтэн цэргүүд онцгой байр суурьтай байсан агаад их цэргээс ялгаатай нь тэдний хувьд тайван цагийн алба гэж байсангүй.

Цэргийн ийм зохион байгуулалтыг монголчууд л анх гаргасан юм биш, урьд өмнө нь түрэг угсааны улс үндэстнүүдийн цэрэг ч иймэрхүү бүтэцтэй байжээ. Гэхдээ шинэ зүйл гэвэл бүх нийтээр цэргийн алба хаах үүрэг, тэрчлэн Монголын Эзэнт гүрнийг бүхэлд нь цэргийн зохион байгуулалтад оруулсан явдал юм. Өөрөөр хэлбэл, Монголын Эзэнт гүрэн өөрөө арми болчихсон, цэргийн бүтэцтэй байсан гэж баттайаа хэлж болно. Цэргийн энэхүү бүтэц, түүнтэй холбогдон гарах үүрэг хариуцлага эмэгтэйчүүдэд ч бас ноогддог байсан билээ.

Цэргийн зохион байгуулалтаас ангид хүмүүс бол бүх төрлийн шашны санваартнууд, эмч нар хийгээд эрдэмтэн мэргэд байлаа. Эд цэргийн алба хаахгүйн дээр ямарваа алба татвар төлдөггүй байв. Тэдний гүйцэтгэх үүрэг нь ондоо, аливаа зан үйл үйлдэх ч юмуу, мэргэжлийн ажил алба эрхэлдэг байжээ. Тэднээс гадна

иймэрхүү маягийн үүргээс чөлөөлөгдсөн тусгай эрх дарх бүхий тодорхой бүлгийн хүмүүс бас байсан юм. Ийм тусгай эрхтэй хүмүүсийг *дархан* (энэ ухагдахуун түрэг болон орос хэлэнд мэр сэр тааралддаг) гэж нэрлэдэг. Цэргийн энэхүү зохион байгуулалтыг бүрэн дүүрэн үнэлье гэвэл Чингис хааныг таалаа төгсөх үед монгол цэрэг нийт их цэргийн 30-аадхан хувийг эзэлж байсан гэдгийг харгалзан үзэх ёстой. үүний цаана их цэргийн нэгдэл нягтрал гэж агуу зүйл байгаа нь тодорхой. Энэ их нэгдэл нягтралыг зөвхөн хүчээр бий болгосон гэж болохгүй л болов уу. Үргэлжийн дайн дажин болон цэрэг дайны ололт амжилтууд нь цэрэгжсэн энэ улсыг тогтоон барьж байсан гэвэл илүү оновчтой болох биз.

*Их Засаг* хуульд мөн Монголын Эзэнт гүрний нутгийг бүхэлд нь хамарсан өртөө улааны тогтолцоо, татвар хураамжийг хэрхэн төвлөрүүлэх тухай зохицуулалтууд, тэрчлэн эзэндээ өөрсдийн охидыг үзүүлж, нэг төрлийн гоо сайхны шалгалт өгүүлэхийг монголчуудад үүрэг болгосон заалтууд буй. Ингэснээрээ эзэн нь тэдгээр охидоос өөртөө болон хааны ургийн хан хөвүүдэд зориулан шилж авдаг байжээ.

Өнөө үед уламжлагдан ирсэн хууль тогтоомжийн нэлээд нь эрүүгийн эрх зүйд хамаарна. Тэдгээрт заасан гэмт үйлдлүүдийг дотор нь шашин болон ёс зүй, тогтсон ёс заншлын эсрэг гэмт үйлдэл, эзэн хаан болон төрийн эсрэг гэмт үйлдэл, бусдын амь нас болон хувийн ашиг сонирхлын эсрэг гэмт үйлдэл хэмээн ангилж болохоор байна.

Эрүүгийн эрх зүйн тогтолцооны гол зорилго нь гэмт этгээдийг бие махбодийн хувьд устган үгүй хийх явдал мөн. Тийм ч учраас цаазаар авах ял эн тэргүүнд тавигдсан байна. Гэхдээ гэмтнийг түр баривчлах, нутаг заах, өөр газар орон руу цөлөх зэргээр тодорхой хугацаагаар зайлуулах боломжууд бас байсан. Тэрчлэн мөнгө, эд зүйлээр торгохоос гадна биеэр шийтгэх ялыг бас эдлүүлдэг байжээ. Хэрэг үйлдсэн гэмт этгээдийг зөвхөн өөрийг нь шийтгээд зогсохгүй, түүний эхнэр хүүхдүүд буюу гэр бүлийнхнийг тэр чигээр нь, цэргийн албатай нь холбоотой бол хамт алба хааж буй нөхдийг нь ч бас цуг шийтгэх явдал тохиолдож байв.

Өн залгамжлах эрх, түүнчлэн гэр бүлийн эрх зүйн холбогдолтой заалтууд ч *Их Засаг* хуульд орсон байна. Монголчуудад олон эхнэр авах ёс байсан, гэхдээ хамгийн анхны авааль эхнэр онцгой байр суурь эзэлдэг ёсноос Чингис хаан өөрөө хүртэл гажсангүй. Эдийн засгийн талаас нь л дийлж байвал хэн ч гэсэн хүссэн тоогоороо эхнэр, дагавар эм авах бололцоотой байв. Өв хөрөнгийг хуваах болоход өмчийн гол хэсэг ахмад хөвүүнд ноогдоно. Харин отгон хүү гал голомтоо сахиж үлдэхийн хамт өөрийн төрсөн эхээс бусад бүх эмс хүүхнүүдийг өвлөн авдаг ёстой байжээ.

Эдгээрээс гадна эдийн засгийн харилцааг зохицуулсан олон тооны заалтууд байсан нь илэрхий байна. Чингис хаан эдийн засгийн солилцоонд ихээхэн ач холбогдол өгдөг байсан болж таарч байгаа юм. *Их Засаг* хуулийн дотор байгаа нэг л заалт бидэнд тун хачирхалтай санагдаж байна. Түүнд дампуурлын тухай өгүүлсэн байх ба гурав дахь удаагаа дампуурсан этгээдийг цаазаар авахаар заажээ.

*Их Засаг* хуулийн агуулгыг дараах байдлаар дүгнэж болохоор байна. Үүнд, өөр хоорондоо туйлын сул холбоотой, тиймээсээ болоод хяналтандаа байлгахад тун хэцүү нүүдэлч түмнийг нэгдсэн нэг хуультай болгож, түүндээ нүүдэлчдийн амьдралыг дэлхий дахины их гүрний хэрэгцээ шаардлагад нийцүүлэх, тухайлбал цэрэгт сахилга бат, чин үнэнч ёсыг эрхэмлүүлэх, төр (жишээ нь төрчил дутагдал гаргасан хүмүүст ял шийтгэл оноох) хийгээд гэр бүлийг (эхнэр, нөхрөө мэхэлсэн хүнийг шийтгэх) тайван амгалан, дэг журамтай байлгах, шашны талаар уян хатан байх бодлого баримталснаар нийгмийг хагарлаас сэргийлэх зорилтыг тавьжээ.

### 3. 1640 оны Ойрад-Монголын хууль цаазын бичиг (Шинэ Цаазын бичиг)

Монголчуудын засаг захиргаа энэ үед монгол хот айлын үндсэн дээр тулгуурлан тогтож байв. *Хот айл* гэдгийг нэг ургийн садан төрлийнхөн хэмээн ойлгож болно. Засаг захиргааны ийм нэгжид тодорхой хэмжээний нутаг дэвсгэр харъяалагддаг байжээ. Энэ нь тухайн хот айл буюу гэр бүлийн гишүүдэд ноогдсон бэлчээр нутаг

бөгөөд түүнээсээ өөр тийш халин гарч үл болно. Хөрш зэргэлдээ хот айлууд нэгдэн аймаг (эл ухагдахуун өнөөгийн Монголын засаг захиргааны бүтцэд ч байдаг), аймгууд нийлээд отог болно. Нийт отгууд бүгд нийлээд нутаг буюу улс-ыг үүсгэх бөгөөд эдгээр нь үндсэндээ дор бүртээ биеэ даасан ванлигуудын шинжтэй байсан юм. Ванлигууд бие биеэсээ үл хамааран зэрэгцэн оршиж байв. Тэдэнд нэгдмэл хууль ёс гэж байсангүй. Зөвхөн онцгой тохиолдолд, нэн ялангуяа гадаад бодлогын хүрээнд зайлшгүй шаардлага гарвал аль нэг талын санаачлагаар ноёдууд цугларан хэлэлцэх буюу Хуралдай хуралдуулж сул чөлөөт шинжтэй эвсэл холбоо байгуулдаг байсан. Ийм холбоонд хэнийг ч албадан оруулдаггүй байсан төдийгүй уг холбоог өөрийн ашиг сонирхолд бүрэн нийцэхгүй байна гэж үзсэн хэн боловч дуртай үедээ чөлөөтэй гарахыг зөвшөөрдөг байжээ. Эрх баригч хаад ноёдын эрх мэдлийг хуулиар ёс төдий хязгаарладаг байв. Судалгаанд голлон хамрагдсан халимагуудыг бусдыгаа төлөөлж чадахуйц жишээ болж чадна гэж үзвэл, тухайн улсын эзэн нь харьяат нартаа үндсэндээ өөрийн өмч мэт хандаж байжээ хэмээн дүгнэж болохоор байгаа юм. Алба татвар ноогдуулах нь тухайн эзэд ноёдын бүрэн эрх мэдлийн хэрэг байв. Харин лам нар хийгээд язгууртны тодорхой хэсгийнхэн албан татвараас чөлөөлөгдсөн байдаг байлаа.

Отгийг тэргүүлэгч нарыг зайсан гэх бөгөөд тэд юуны өмнө цагдаагийн үүрэг гүйцэтгэж, отгоос хүмүүс гарч явахгүй байхад анхаардаг байв. Тэрээр мөн өрх бүрээс хураан авсан татварыг цуглуулж, харьяа нутаг хошуундаа тайван цагт шүүгчийн ажил эрхэлнэ. Түүний мэдэлд ерөнхийдөө 200 орчим өрх байдаг. Эдгээрийг цааш нь 40 орчим өрхтэй бүлгүүдэд дахин хувааж, дэмч нарт захируулна. Дэмч нарын харьяанд шүлэнгэ нараар толгойлуулсан 20 орчим өрх бүхий бүлгүүд багтдаг. Хэд хэдэн үе шаттайгаар арав арваар нь хуваасан энэ ангилал Чингис хааны цэрэг, төр захиргааны зохион байгуулалтаас улбаатай юм. Нийгмийн байдлаараа Баруун Монголчууд гурван давхаргад хуваагдаж байв. Хамгийн дээд давхаргад хаад ноёд харъяалагдах бөгөөд тэдгээр нь дотроо дээд шатныхан, өөрөөр хэлбэл эрх баригч бүлгийнхэн, төрийн албан хаагчид буюу дунд шатныхан, ажил алба эрхэлдэггүй доод шатны язгууртан угсааныхан гэж мөн

й хушаагдана. Эхний бүлэгт, вангийн цол хэргэмгүй язгууртнууд, мөн хаад ноёдын гэр бүлээс гараагүй төрийн албан хаагчид багтдаг. Дунд бүлэгт, татвараас чөлөөлөгдсөн цэргийнхэн буюу тучид орно. Эцсийн доод шатны бүлэгт гар урчууд, малчид, тариачид зэрэг хүн амын үлдэх хэсгийнхэн харъяалагдаж байжээ. Ихэвчлэн цэргийн олзлогдогсдоос бүрдсэн боол зарц нар хүн амын тоонд ордоггүй тусгай нэг бүлгийг үүсгэдэг байв.

Хувь хүний эрхийн асуудалд маш бага анхаарсан *Их Засаг* хуулийг бодвол 1640 оны хуулинд эрх зүйн энэ салбарыг тухайн үеийн хэрэгцээг бүрэн хангах хэмжээнд авч үзсэн юм. Өр авлагатай холбоотой зохицуулалтууд нь хоёрдугаар зэргийн (маргиналь) шинжтэй байна. Харин ямар нэг захиалагчгүй аж ахуйн үйл ажиллагааг зохицуулахад маш сайн анхаарчээ. Тухайлбал, хүмүүс болон тэдний өмч хөрөнгөд аюул осол нүүрлэсэн тохиолдолд тусламж үзүүлж байхаар заасан байна. Аж ахуйг эрхлэн явуулж буй хүн идэвх зүтгэл гаргасныхаа төлөө хөрөнгийн эзнээс хөлс шан нэхэмжлэн авах эрхтэй байв. Энэ зохицуулалт нь нүүдэлчдийн ахуй амьдралын хэрэгцээ шаардлага, ялангуяа цаг ууртай холбоотой асуудлуудаас урган гарсан юм. Монголын эрх зүй яг энэ талаараа Ромын эрх зүйгээс эрс ялгаатай. Ямартай ч бусдын өмч хөрөнгөд хохирол учруулбал нөхөн төлбөр хийж байхаар заасан байна. Хаясан гэсэн эд юмсыг олбол хэрхэх талаар нэлээд дэлгэрэнгүй заалтууд оржээ. Эдгээр нь юуны өмнө алдуул мал, гэдгээрийг олохтой холбоотой заалтууд юм. Гэр бүлийн эрх зүйн талаар нарийн зохицуулсан зүйлс бий. Үүнд мөн л олон эхнэртэй байж болохыг иш үндэс болгожээ. Гэр бүл болох угтвар нөхцөл нь эхнэрийг худалдан авах явдал юм. Ийнхүү худалдан авахад голлох үүрэг бүхий хүргэний зүгээс эхнэр авахад зориулан гаргах хөрөнгө, мөн бэрийн эцгээс охиндоо инж болгон өгөх эд хөрөнгийн асуудлыг хуулиар зохицуулдаг байжээ. Хөрөнгийн хэмжээг оролцогч этгээдүүдийн нийгмийн байр сууринаас хамааруулж нарийвчлан тогтоодог байна. Эхнэрийн төлөөсөнд өгөх хөрөнгийг гаргаснаар сүй тавьсан гэж үзнэ. Эрүүгийн эрх зүйн талаар нэлээд дэлгэрэнгүй заалтууд оржээ. Үүнд төрийн эсрэг, хаад ноёдын эсрэг, гэр бүлийн эсрэг, ёс заншлын эсрэг, мөн хүний амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгийн эсрэг гэмт үйлдлүүдэд шийтгэл оноож байхаар заасан байдаг. Оноосон ял шийтгэлийн зарим нь гэмт

этгээдийг хийсэн үйлдэлдээ гэмшүүлэхэд, зарим нь тухайн хүний хувийн эрх ашгийг адилхан хохирооход чиглэж байв. Давын өмнө эд юмсаар торгох шийтгэл зонхилж байсан ба үүнд уг этгээдийн бүх эд хөрөнгө буюу түүний хэсгийг хураан авах хүртэл арга хэмжээ орж байсан юм. Торгуулиас бусад төрлийн шийтгэлийг ихээхэн зөөлрүүлсэн байдаг. Тухайлбал, *Их Засаг* хуулиас ялгаатай нь цаазаар авах ялыг ганцхан газарт дурджээ. Түүнчлэн, хүний эд эрхтнийг тасдаж гэмтээх, ташуурдах зэрэг биеэр эдлүүлэх ял шийтгэл ховорхон орсон байна. Харин хувь хүний статусыг үгүй хийх, хорьж шийтгэх ял шинээр бий болжээ. Албан тушаалаас нь буулгах арга хэмжээ авдаг болов. Мөн бусдын төлөө, тухайлбал эхнэр нь нөхрийнхөө өмнөөс, эсвэл нөхөр нь гэр бүлийнхээ өмнөөс ял зэм хүртэх боломжийг ч хуулинд тусгасан байна. *Их Засаг*-тай харьцуулбал хууль ерөнхийдөө нэлээд зөөлөрсөн санагдана. Эрүүгийн эрх зүйг ийнхүү өөрчлөн шинэчилсэн нь буддын шашны нөлөөтэй холбоотой болов уу. Уг хуульд шашны санваартнууд, хаад ноёд, бусад эрхтэн дархтнуудад зориулсан тусгай заалтууд ч байсан юм.

Шинэ *Цаазын бичиг*-т биднийхээр захиргааны эрх зүй гэж нэрлэмээр зүйлс харьцангуй хоёрдугаар зэргийн шинжтэйгээр оржээ. Тэдгээрээр өмнө нь миний дурдаж байсан орон нутгийн засаг захиргааны бүтцийн асуудлыг зохицуулж, тухайн бүс нутгийн дарга захирагчийн эрх үүргийг тодорхойлсон байдаг. Энэ хуульд "нийгмийн асуудал"-ыг ямар нэг хэмжээгээр тусгасан нь анхаарал татаж байна. Түүнд, ядуучууд, зайлшгүй тусламж шаардлагатай хүмүүсийг харж хандах талаар тусгайлсан зохицуулалт хийж, тэдгээрийг биелүүлэхийг ороннутгийн захиргааны байгууллагуудад үүрэг болгожээ. Захиргааны эрх зүйд холбогдох заалтуудын үлэмж хэсгийг өртөө шуудан, түүний найдвартай байдлыг хангахад зориулсан байна. Энэ бүхнээс гадна цэргийн албатай холбоотой, эрэлхэг зоригтнуудыг шагнах, мөн цэргээс зугтсан буюу дайсны өмнө хулчгар байдал гаргасан хүмүүсийг шийтгэх тухай тусгайлан заасан заалтууд бас байдаг юм.

#### 4. Дүгнэлт

Энд зөвхөн тойм төдийгөөр товч авч үзсэн дээрх хуулиуд нүүдэлчин ардын хэрэгцээнд тохирсон хууль цааз нэгэнт бий болон хөгжсөнийг харуулж байна. Чингис хаан хэдийгээр Хятадын төрийн тогтолцоог хараандаа аваад байсан боловч нүүдэлчний нийгмийг "бусдаас илүүд үзвэл зохих төрийн хэлбэр" гэдгийг иш үндэс болгож байжээ. Түүний бий болгосон хууль цаазын зарим заалтууд нүүдэлчний нийгмийн элементүүдийг улам бүр бэхжүүлэхэд чиглэсэн буюу эсвэл түүнд шууд зохицсон байдаг. Энэ нь түүний дараа тогтоогдсон эрх зүйн хэм хэмжээнүүдэд ч нэгэн адил хамаарна. Ямартай ч өмч болон газар өмчлөх эрхийг зохицуулсан хуулиуд гараагүй нь дээрхтэй холбоотой юм. Өнөөгийн Монгол Улсад ч гэсэн бэлчээр нутгийг ямар боловч хувь хүнд өмчлүүлэх боломжгүй, нийтийн хэрэгцээнд зориулагдсан хэвээр байгаа бөгөөд түүнийг ашиглах өөр хоорондоо өрсөлдөгч олон янзын хэлбэрийн талаар хуулийн тодорхой зохицуулалт ч алга. Харамсалтай нь энэ байдал өөрчлөгдөж байх шиг санагдана. Бэлчээр нутгийг хуваан эзэмших хүслийн ард талд гадаадын уул уурхайн компаниуд зогсож байдаг. Гэвч нүүдэлчний нийгмийг ухраана гэдэг бол 800 гаруй жилийн түүхтэй нүүдэлчний соёлыг эцэс болгоно гэсэн үг юм. Орчин үеийн улсууд мөхөж буй ургамлыг хамгаалах үүргээ ухамсарладаг атлаа мөхөж буй соёлыг хамгаалах тухай ярьдаггүй нь илт. Гэтэл соёл гэдэг бол барьсан байшин барилгаараа бус, амьдралын тодорхой хэв шинжээрээ илэрхийлэгддэг зүйл билээ.

Хуулийн янз бүрийн зохицуулалтууд бие биеэсээ холдон салсан улс үндэстнүүдийг ямар нэг хэмжээгээр ойртон нягтруулах тухайн үеийн шаардлагаас үүдэн гарсан юм. Тэгэхээр тэдэнд улс үндэстнүүдийг ойртон нягтруулах тодорхой үүрэг байдаг гэсэн үг. Энэ утгаараа дээр дурдсан Монголын хуулиуд өнөөгийн нэгдмэл Европыг байгуулахын төлөө улс орнуудын хуулийг бие биетэй нь уялдуулах буюу нэгдсэн нэг хуультай болох гэсэн оролдлогуудаас төдийлөн ялгарахгүй. Хэрэв та хүсвэл, хэрэв энэхүү харьцуулалтыг учир утгагүй зүйл гэж бодохгүй байгаа бол Европын үндсэн Хуулийн Гэрээнд заасан чиг зорилгыг *Их Засаг* хуультай харьцуулаад үзэгтүн. Энэ нь шинээр бий болгосон хууль

ямар хэмжээнд, ямар нөхцөлд улс үндэстнүүд ойртон нягтрах хүчин зүйл болж, юуны өмнө өөрийн гэсэн өвөрмөц онцлог бүхий шинэ үндэстнийг төрүүлж чадах вэ гэдэг сонирхолтой асуулт тавихад биднийг хүргэж байна. Энэ асуулт тухайн үедээ Чингис хаанд яг л өнөөгийн бидэн шиг тавигдаж байсан юм. Түүний хувьд, засаг төрийн эрх барьж байх хугацаандаа тэрээр дээр өгүүлсэн үндэстний өвөрмөц онцлогийг бий болгож чадсан нь лавтай. Гэхдээ энэ нь өнөөгийн цаг үед хүлээн авахын аргагүй хүчин зүйлс, арга хэрэгсэлд тулгуурласан байдаг.

Чингисхааны цоошинээр бий болгосон хууль цааз нь түүний өөрийн хаанчлал, мөн түүний гэр бүлийнхний ноёрхлыг бэхжүүлэхэд чиглэсэн юм. үүнтэй нэгэн зэрэг Чингис хааны мэндэлсэн тухай болон түүний ургийнхан хэрхэн үүссэн тухай домгууд гарч иржээ. Хожмын хаадын удмынхан ч эдгээрийг ашигласан байдаг нь энэхүү эхлэл хойшдоо ямаршуухан үр нөлөөтэй байсныг нотлон харуулдаг билээ. Төмөр Ленк 1370 онд төр засгийн толгойд гарч ирэхдээ Чингис хааны удмын хүн гэдгээ өмнөө барьсан байдаг. Тэрээр хууль ёсны эзэн болсноо мөн л тэнгэр бурхны өршөөл хишиг гэж үздэг байв. Харин өөрийгөө ямагт эхийн талаасаа Чингис хааны удамтай гэдэг байсан тул "хаан" цол хэрэглэхээс татгалздаг байжээ. Төмөр өөртөө "эрхэм дээд жанжин" цол олгож, хэрэг дээрээ засаг эрхийг барьж байснаа баталгаажуулахын тулд Цагаагадын удмын нэгэн Чингисийг хаанд өргөмжлөөд, Баасан гараг болгоны мөргөлийн хурал дээр түүний нэрийг өөрийнхөө нэртэй цуг дуудаж байхаар болгосон байна. Цаашилбал, засаг төрийг барих эрхээ хууль ёсоор Чингис хаантай холбон баталгаажуулах үүднээс түүний удмын хэд хэдэн бүсгүйчүүдийг хатнаа болгон авснаар Чингисийнхний хүргэн хэмээгдэж онцгой эрх дарх эдлэх боломжтой болжээ.

Харин Төмөр Ленк өөрөө гэхээсээ илүү хожмын түүхчид түүнийг Чингис хаантай ураг төрлийн холбоотой, алтан ургийн өвөг дээдсээс гаралтай хүн болгох зайлшгүй шаардлагатай гэж үзсэн бололтой байдаг юм. Дайн тулааныг удирдах, мөн засаг захиргааны болон хууль цаазын хэргийг явуулахдаа Төмөр Чингисийнхний уламжлалыг чанд баримталдаг байв. Гэвч түүнд нэг хүндрэл байсан нь тэрээр Чингис хааныг бодвол мусульман

шашинтан байсан ба тэгээд ч өөрийн хууль ёсны эрхийг мусульман шашинтны ёсоор баталгаажуулах гэж оролдож байсан юм. Төмөр тийм ч учраас Шариагийн хууль тогтоох эрхийг хэвээр үлдээж, олон тооны тосгон суурингуудад тансаг гоё барилга байшин баруулан, мусульман шашинт эрдэмтэн мэргэдэд хүндэтгэлтэй ганддаг байжээ. Чингисийн болон мусульман шашинтны үзлийг баримталсан энэхүү хоёр талт бодлогоо Төмөр Ленк өөрөө гэдгийг түүний үеийн олон хүн нэг их хүндрэлтэй зүйлд тооцож байгаагүй болов уу. Түүний залгамжлагчид харин дээрх хоёр талт стратегийг баримтлаагүй бөгөөд мусульман шашинтны хууль ёсны мөрдөхийг илүүтэйд үзсэн байдаг.

XV зуунд Чингис хааны гарал үүсэлд тулгуурлан хууль ёсны эрээ тунхагласан бас нэгэн Эзэнт Улс ноёрхлоо тогтоожээ. Чингисийнхэн болон Төмөрийнхний нэгэн адил тэдний ноёрхлын тогтолцоонд нэг ойлгомжгүй зүйл байсан нь эрх мэдлийг гэр бүл, удам угсааны хүрээнд хуваарилдаг түрэг-монгол загвар юм. Тус Эзэнт гүрэн Чингисийн удам угсааг баримтлан хууль ёсны болсноор монгол ёс заншил хийгээд хууль цаазыг мөрдөх явдал эргэн сэргэсэн байдаг. Энэ хооронд гол төлөв Лалын шашинт хүн ямыг захирахын зэрэгцээ өөрсдөө ч уг шашинд орсон монгол хаад ноёрхлоо урт удаан хугацаагаар хадгалахын тулд хууль ёсны эзэн болох үйлдлээ Лалын шашинтны ёсоор гүйцэтгэдэг болоод байсан юм. Үүнийгээ өөр өөр янзаар үйлддэг байсан. Ерөнхийдөө энэхүү лалчлах үйл явцын нөлөөгөөр *Их Засаг* болон *Цаазын бичиг* хуулиуд монгол хаадыг хууль ёсоор өргөмжлөх эх сурвалж болох талаасаа үнэ цэнээ улам бүр алдаж, олон газарт Лалын шашинтны хууль үйлчилж байсныг бичиж үлдээх нь зүйтэй болов уу (Жишээ нь, Алтан Ордны Улсад XIV зуунд л гэхэд *Их Засаг* хуулийн зөвхөн гол гол заалтуудыг л хэрэглэж байснаас бус үндсэндээ бол Лалын шашинтны хуулийг мөрддөг байв).